

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

20.. оны .. сарын... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тогтоол, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.5, 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолд дор дурдсан агуулга бүхий долдугаар хавсралт нэмсүгэй:

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны  
7 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр  
тогтоолын долдугаар хавсралт

**ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧЭЭС  
ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ**

№	Үйлчилгээ	Үйлчилгээний хөлс	Хугацаа
1	виртуал хөрөнгийн үйлчилгээ тус бүрээр бүртгүүлэх хүсэлт гаргах	1,000,000.00 төгрөг	Тухай бүр
2	виртуал хөрөнгийн үйлчилгээ тус бүрээр үйл ажиллагааг сэргээх	5,000,000.00 төгрөг	Тухай бүр
3	виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих	үйл ажиллагааны явцад олсон нийт шимтгэлийн орлогын 0.1 дүнтэй тэнцүү хэмжээний төгрөг	Тухай бүр
4	нэг болон олон төрлийн виртуал хөрөнгийг хооронд нь арилжих		Тухай бүр
5	виртуал хөрөнгийг шилжүүлэх		Тухай бүр
6	виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах	10,000,000.00 төгрөг	Жил бүр
7	виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлэх.	15,000,000.00 төгрөг	Жил бүр

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолын 1 дэх заалтын “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсийг зургаадугаар хавсралтаар” гэсний дараа “; “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсний хэмжээ”-г долдугаар хавсралтаар” гэж нэмсүгэй.

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолын тавдугаар хавсралтаар баталсан "Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх

журам"-ын 3.2 дахь хэсгийн “хөдөө аж ахуйн биржийн зуучлагчийн” гэсний өмнө “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон” гэж, 3.3 дахь хэсгийн “6” гэсний дараа “, 7” гэж тус тус нэмсүгэй.

4.Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолын тавдугаар хавсралтаар баталсан "Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам"-ын 1.1 дэх хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

“1.1.Энэ журмаар үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд, даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-оос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс /цаашид “хөлс” гэх/-ийг төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.”

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН